

Санхүүгийн хяналт шалгалт
хийсэн дүнгийн тухай

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Засаг даргын баталсан 2022 оны 06 дүгээр сарын 17-ны өдрийн 1/15 дугаар удирдамжийн дагуу Баян-Агт сумын Соёлын төвийн 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Соёлын тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ж.Оюун би 2022 оны 09 сарын 19-ний өдрөөс хуанлын 6 хоногт багтаан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

ГУРАВ. ШАЛГАЛТАД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Баян-Агт сумын Соёлын төвийн 2021 оны касс, харилцах дансны орлого, зарлагын гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, олговор, албан томилолтын бодолт, олголт, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдлийн байдал, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, шатахууны олголт, зарцуулалт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг хамруулав.

**ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

Баян-Агт сумын Хүрэмт багт байршилтай 3184331 регистрийн дугаартай Соёлын төв нь эрхлэгч, орон нутаг судлах танхимын ажилтан, номын санч, техникч сантехникч, үйлчлэгч нярав гэсэн 5 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Тус төвийн 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд *нэгдүгээр гарын үсгийг* 01 сарын 01-ний өдрөөс 03 сарын 01-ний өдөр хүртэл эрхлэгч Х.Гансүх, 03 сарын 01-ний өдрөөс 07 сарын 20-ны өдөр хүртэл номын санч Д.Алимаа, 07 сарын 20-ны өдрөөс 12 сарын 31-ний өдрийг дуустал эрхлэгч Ч.Гантулга, *хоёрдугаар гарын үсгийг* 01 сарын 01-ний өдрөөс 12 сарын 31-ний өдрийг дуустал Г.Соёлмаа нар зурсан ба сумын төрийн санд бүртгэлийн 100040135090 дугаар дансаар хөрөнгө мөнгийг захиран зарцуулж ирсэн ба нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох “CTS” программаар бүртгэн хөтөлжээ.

Тус төвийн няравын ажлыг техникч Д.Болор-Эрдэнэ 01 сарын 01-ний өдрөөс 03 сарын 04-ний өдрийг хүртэл, үйлчлэгч Г.Билгүүн 03 сарын 04-ний өдрөөс 12 сарын 31-ний өдрийг хүртэл тус тус хавсран гүйцэтгэжээ.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Булган аймаг дахь Төрийн аудитын газраас тус сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар “ЗӨРЧИЛГҮЙ” санал дүгнэлт өгсөн байна.

Бусад байгууллагаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

ЗУРГАА. ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Баян-Агт сумын Соёлын төв нь шилэн дансны цахим хуудсанд **2021 онд** мэдээлбэл зохих 161 мэдээллээс 159 мэдээллийг тогтоосон хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Мэдээлэл байршуулсан байдлыг шалгаж үзэхэд; өмч хөрөнгөтэй холбоотой 10 шийдвэр гарсанаас 3 шийдвэрийг байршуулж, 7 шийдвэрийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 10 удаагийн 120,681.9 мянган төгрөгийн орлогын гүйлгээг огт мэдээлээгүй, 8 удаагийн 68,030.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээнээс 5 удаагийн 48,174.8 мянган төгрөгийн гүйлгээг байршуулж, 3 удаагийн 19,855.7 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй.

2022 оны 1-8-р сард мэдээлбэл зохих 109 мэдээллээс 98 мэдээллийг тогтоосон хугацаанд нь мэдээлж, 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

ДОЛОО. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Баян-Агт сумын Соёлын төвийн 2021 оны касс харилцах, няравын үндсэн хөрөнгө, бараа материалын тайлан баримт, төсвийн шууд захирагчийн гаргасан А, Б шийдвэр, цагийн бүртгэл, хагас, бүтэн жилийн хөрөнгө, бараа материалын тооллогын бүртгэл, санхүүгийн тайлан, хөдөлмөрийн дотоод журам зэрэг холбогдох бусад баримт материалд тулгуурлан эрхлэгч Ч.Гантулга, нярав Г.Билгүүн нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

7.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:

2021 онд орон нутгийн төсвөөс 133,318.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 525.0 мянган төгрөг орж нийт 133,843.6 мянган төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдсэнээс үйл ажиллагааны зардалд 132,588.8 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 1,254.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 500.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 25.0 мянган төгрөгийн орлого оруулж, 475.0 мянган төгрөгөөр тасалсан.

Төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлт:

/мянган төгрөг/					
Эдийн засгийн ангилал	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт + Хэтрэлт -	Төсвийн нийт зардалд эзлэх хувь
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	48,218.9	47,886.4	+332.5	36.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд	6,509.6	5,930.9	+578.7	4.5

	төлөх шимтгэл				
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,418.6	53,100.0	+318.6	40.0
2104	Хангамж, бараа материалын зардал	325.0	325.0		0.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,478.0	1,478.0		1.1
2107	Томилолт, зочны зардал	58.0	58.0		0.04
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,010.0	1,960.0	+50.0	1.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,900.5	21,800.5	+100.0	16.4
23001	Бусад хөрөнгө		50.0	-50.0	0.03
	Дүн	133,918.6	132,588.8	+1,329.8	100

Цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын талаар:

Баян-Агт сумын Засаг даргын 2021 оны 12 сарын 21-ний өдрийн Б/34 дугаар захирамжийг үндэслэн эрхлэгч Ч.Гантулгад үндсэн цалингийн 40%-иар, тус сумын Соёлын төвийн эрхлэгчийн 2021 оны 12 сарын 14-ний өдрийн А/09 дугаар тушаалыг үндэслэн нэр бүхий 4 албан хаагчид үндсэн цалингийн 40%-иар нийт 1,265.4 мянган төгрөгийн ажлын үр дүнгийн урамшуулалт цалин олгосон байна.

2021 онд 1 албан хаагчид 500.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгож, бүрэн суутгасан.

Албан хаагчдын цалингаас хамтын санд албан хаагч бүрээс сар бүр 10.0 мянган төгрөг буюу 1-12-р сард нийт 610.0 мянган төгрөг суутгаснаас 510.0 мянган төгрөгийг номын санч Д.Алимаагийн хамтын сангийн 5271144731 дугаар харилцах дансанд шилжүүлж, дутуу шилжүүлсэн 100.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгасан байна.

7.2 Өглөг, авлагын талаар:

Өглөгийн дансны эхний үлдэгдэл ХХОАТ-ын 359.8 мянган төгрөгийн өглөгийг бууруулж, 1,2-р сарын цалингаас суутгасан хамтын сангийн 100.0 мянган төгрөгийг өглөгөөр тайлагнасан байна.

Тайлант онд ХХОАТ-ын 12.9 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн 30.3 мянган төгрөг нийт 43.2 мянган төгрөг илүү шилжүүлсэнийг тайланд авлагаар тусгасан байна.

7.3 Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж, орон сууц	1,349,765,600.00	0.00	0.00	1,349,765,600.00
2	Машин тоног төхөөрөмж	24,732,278.00	0.00	0.00	24,732,278.00
3	Тавилга, эд хогшил	11,416,764.00	0.00	0.00	11,416,764.00
4	Номын фонд	11,686,669.01	267,300.00	0.00	11,953,969.01
5	Программ хангамж	100,000.00	0.00	0.00	100,000.00
6	Бусад биет бус хөрөнгө /газар/	7,676,000.00	0.00	0.00	7,676,000.00
	Дүн	1,405,377,311.01	267,300.00	0.00	1,405,644,611.01

2021 онд иргэн О.Сугараас “Татварын эрх зүйн баримт бичгийн эмхтгэл” ном 50.0 мянган төгрөгөөр худалдан авсан, Нутгийн яруу найрагч, шинжлэх ухааны доктор На.Батболд, Үндэсний төв номын сан, Ц.Анандбазарын ажлын албанаас нийт 217.3 мянган төгрөгийн 22 нэр төрлийн 35 ширхэг ном үнэ төлбөргүйгээр өгсөн байна.

7.4. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:

№	Үзүүлэлт	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
1	Бичиг хэрэг	197,204.00	60,000.00	111,604.00	145,600.00
2	Аж ахуйн материал	13,640,704.20	174,700.00	194,700.00	13,620,704.20
3	Барилгын засвар	0.00	1,398,000.00	1,398,000.00	0.00
4	Түлш, шатах тослох	0.00	118,020.00	118,020.00	0.00
5	Тусгай зориулалт	90,000.00	0.00	0.00	90,000.00
	Дүн	13,927,908.20	1,750,720.00	1,822,324.00	13,856,304.20

Төсвийн хөрөнгөөр нийт 1,750.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, байгууллагын үйл ажиллагаанд 1,822.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, шалтгаан

1. Агуулахын бүртгэл огт хөтлөөгүй.
2. Ажлын цаг ашиглалтын бүртгэлд цаг бүртгэгч гарын үсэг зурдаггүй.
3. Шаардах хуудаст материал хүссэн албан хаагчийн нэр бус няравын нэрийг бичиж буруу хөтөлсөн.
4. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын комисст бүртгэлийн программаас үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын бүртгэлийг хэвлэн гаргаж, тоолуулсан, тооллогын комисс тооллогоор бэлэн тоологдсон хөрөнгө, материалыг нэгтгэж “тооллогын бүртгэл” гаргаагүй, программаас гаргасан тооллогын бүртгэлд гарын үсэг зурсан, эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг батлагдсан маягтын дагуу хөтлөөгүй.
5. **2021 онд** мэдээлбэл зохих мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, өмч хөрөнгөтэй холбоотой 10 шийдвэр гарсанаас 7 шийдвэрийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 10 удаагийн 120,681.9 мянган төгрөгийн орлогын гүйлгээг огт мэдээлээгүй, 8 удаагийн 68,030.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээнээс 3 удаагийн 19,855.7 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй. **2022 оны 1-8-р сард** мэдээлбэл зохих мэдээллээс 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Авсан арга хэмжээ, мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө өгсөн байдал

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 1 албан шаардлага үйлдэж, байгууллагын удирдлага, нярав нарт анхан шатны баримтын бүрдэлт, хөтлөлтийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

Дүгнэлт

Тус төвийн анхан шатны баримтын бүрдэлт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт хангалттай, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр дотоодын хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулиуд болон холбогдох тушаал, дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж, гүйцэтгэлийг хянан баримтжуулж, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх

Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргахгүй байхад анхааран тодорхой ажил зохион байгуулж, албан шаардлагын биелэлтийг хангах

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Ж.ОЮУН

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА,
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

Б.БАТТУЛГА

